

ГХС-ИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО

ШУТИС-ийн ГХС-ийн ҮЭ-ийн хороо нь хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн чөлөөт байгууллага юм. ГХС-ийн ҮЭ-ийн хороо нь нийгэмд болон гишүүддээ үйлчилдэг, ашгийн бус байгууллага, хуулийн этгээд мөн.



Тус хороо нь 2009 оны 10 дугаар сарын 12-нд бүртгүүлж, гэрчилгээ авснаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба анхны даргаар нь англи хэлний багш Б.Эрдэнэчимэг, тэргүүлэгч гишүүдээр нь Б.Сонинцэцэг, Алимаа, Чимэдлхам, Цэнд-Аюуш нар хамт олны олонхын саналаар сонгогдон, 2009-2017 он хүртэл 8 жилийн хугацаанд хамтарч, нэг баг болон амжилттай ажилласан.



Зураг 1. ҮЭХ-ны дарга Б.Эрдэнэчимэг, тэргүүлэгч Э.Чимэдлхам



Зураг 2. ҮЭХ-ны дарга Б.Эрдэнэчимэг, тэргүүлэгч Б.Сонинцэцэг



Зураг 3. Урд эгнээний зүүн гар талаас Б.Мөнхцэцэг, Н.Оюунцэцэг, Б.Сонинцэцэг, арын эгнээний зүүн гар талаас Т.Цэнд-Аюуш, Ч.Баярмаа (2022)

2017 онд болсон тайлан сонгуулийн хурлаар монгол хэлний багш Б.Сонинцэцэг ҮЭХ-ны даргаар, Б.Мөнхцэцэг, Б.Ундраа, М.Ганболд, Т.Цэнд-Аюуш нар тэргүүлэгч гишүүдээр сонгогдон, 2022 он хүртэл ажилласан.

ГХС-ийн ҮЭХ-ны сонгууль 2021 онд болох байсан ч ковидын нөхцөл байдлын үед хамт олны сонгууль явуулах боломжгүй, бас цахим сонгууль явуулахыг тооцохгүй байсны улмаас

2022 оны 01 сард тайлан, сонгуулийн хурлаа хийж, багаараа дахин сонгогдсон. Тэргүүлэгч гишүүн М.Ганболд ажлаас гарсан, Б.Ундраа саналаараа больсон тул багш Н.Оюунцэцэг, салбарын тэнхимийн туслах ажилтан Ч.Баярмаа нарыг нөхөн сонгосноор, одоо тус ҮЭХ нь 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

ШУТИС-ийн ҮЭНХ-ны Хяналтын хорооны гишүүнээр ГХС-иас Н.Оюунцэцэг 2014-2016 онд, Ц.Энхбаатар 2016-2020 онд сонгогдон ажилласан ба Хяналтын хорооны гишүүн нь ҮЭ-ийн холбооноос баталж гаргасан шийдвэр, явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчилтэй шийдвэр гаргавал цаг тухайд нь хүчингүй болгуулах, буруу үйл ажиллагааг зогсоох, санхүүгийн төвлөрөлт, зарцуулалтын байдлыг шалгаж дүгнэлт гаргах, шалгалтын дүгнэлтийг мэдээлэх зэрэг үүрэг гүйцэтгэсэн.



ГХС-ийн гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрхийг хамгаалж дэмжих үндсэн чиглэлтэй, 23 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн тус хороо одоо 99%-ийн гишүүнчлэлтэй бөгөөд нийт 84 гишүүнтэй.

2017 оноос 2022 оны 10 сар хүртэлх 6 жилийн хугацаанд МБШУ-ны ҮЭ-ийн холбоодын ээлжит бага хурал, ШУТИС-ийн ҮЭНХ-ны хурал, ГХС-ийн 33-ийн хурал, ШУТИС-ийн ҮЭНХ-ны тайлан, сонгуулийн хурал (2017), МБШУҮЭХ-ноос зохион байгуулсан цуглаан, жагсаал, Төрийн өмчийн их, дээд сургуулийг механикаар нэгтгэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотой гишүүдийн санал сонсох уулзалт хурал, ШУТИС-ийн хичээлийн 4-р байрны барилгатай холбоотой бүх багш, ажилтны цахим хуралд гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрхийг



Зураг 4. Тайван жагсаалд оролцож буй багш нар (2022) Т.Цэнд-Аюуш, Г.Ариунбямбаа, Т.Гаамаа, М.Нямдолгор, Б.Банзрагч

хамгаалах, цалин хөлсийг нэмэгдүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх, баталгаажуулах зорилгоор өөрөө болон гишүүдтэйгээ идэвхтэй оролцсон байна.

ШУТИС-ийн Хамтын гэрээ байгуулах хэлэлцээр (2019), Хамтын гэрээний төсөл боловсруулах хурал (2017-2022), 2019 онд ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам шинэчлэх хэлэлцээр зэрэг хамтын асуудлыг зохицуулах гэрээ, хэлэлцээр хийх, журам боловсруулахад санаачилгатай оролцох, батлуулахад идэвхтэй нөлөөлөх, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буйд хяналт тавих, улмаар тухайн асуудлаар судалгаа гаргаснаар асуудлаа шийдвэрлүүлэх зэрэг олон чухал ажлыг ШУТИС-ийн ҮЭНХ-тойгоо хамтран гүйцэтгэсэн. Тухайлбал:

Багш, ажилтны сул зогсолтын асуудлыг хөндөж тавьснаар 2017 онд 14 багш, 2 ажилтанд 75%-иар бодож, сул зогсолтын олговрыг анх олгож эхэлсэн. Мөн ЗГ-ын тогтоолоор коллежоос ирсэн багш, ажилтны судалгааг 2017 онд гаргасныг ШУТИС-ийн ҮЭНХ нэгтгэн, асуудал дэвшүүлж, санал оруулснаар Хамтын гэрээнд тэтгэврийн тэтгэмж олгох заалтыг тусгайлан оруулж, 2018 оноос тэтгэмж олгодог болсон. Багшийн илүүгийн илүү цагийн судалгаа гаргаж, илүүгийг илүү олгох ажлыг 2017 оноос Хамтын гэрээнд заалт болгосон шийдвэрлэсэн.

Үйл ажиллагааны чиглэл



Гишүүддээ Хамтын гэрээний шинэчлэгдсэн, өөрчлөгдсөн заалт, ШУТИС-ийн дүрэм, журам болон хөдөлмөрийн шинэ хууль танилцуулах, судлах ажлыг зохион байгуулж, үүнтэй холбоотойгоор АХА тэмцээн зохиож (2019), НД-ын хууль, тэтгэмж, тэтгэврийн хуулийн талаарх сургалтад гишүүдээ хамруулж (2019), гишүүн бүрт хөдөлмөрийн шинэ хууль тараасан. Гишүүддээ зориулсан 1 ажлыг жил бүр төлөвлөдөг болсны дагуу “Баримт бичиг боловсруулах” (2021), “Зөв бичих дүрэм ба журамласан үгс” (2019) сэдэвт үнэ төлбөргүй сургалт, мөн Г.Гэрэлмаагийн “Судалгааны ажил бичих арга зүй” сэдэвт сургалтыг зохион явуулсан.

ШУТИС-ийн ҮЭНХ-ноос явуулсан болон хороонд ирүүлсэн албан бичгийг гишүүддээ тайлбартайгаар танилцуулах, Хамтын гэрээнд оруулах саналыг гишүүдээс жил бүр авч нэгтгэн, ҮЭНХ-нд хүргүүлэх, ШУТИС-ийн ҮЭ-ийн Хяналтын хороонд санхүүгийн болон үйл ажиллагааны баримтаа шалгуулах (2019, 2021), ажлын байрны нөхцөлд үзлэг шалгалт хийлгэх албан бичиг хүргүүлэх (2019), А, Б, В цаг тооцох журамд өөрчлөлт оруулах саналыг нэгтгэж хүргүүлэх, мөн харилцагч Хаан банкинд 15 удаагийн албан бичиг үйлдэх, СБД-ийн НДХ-т 9 удаагийн албан бичиг хүргүүлэх, Мэргэжлийн хөтөлбөрийн давхардал, техник технологийн орчуулагч бэлтгэх үндсэн бааз суурь ШУТИС-д төвлөрөх ёстойг тайлбарласан үндэслэл, тайлбар бүхий албан бичгийг ШУТИС-ийн ҮЭНХ-нд хүргүүлэх (2021), Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой албан бичиг үйлдэх, улмаар ШУТИС-ийн захиргаанд Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой шаардлага хүргүүлэх (ШУТИС-ийн ҮЭНХ-той нэгдэж), ШУТИС-ийн хичээлийн 4-р байрны барилгатай холбоотой хурлаас гаргасан эсэргүүцлийн бичигт гишүүний гарын үсэг цуглуулах зэргээр албан баримт бичиг боловсруулан үйлдсэн.

2017-2021 оны хугацаанд хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулах, нийгмийн баталгаагаа хангуулах, тусламж дэмжлэг хүсэх асуудлаар ҮЭХ-нд хандсан 110 өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсний дотор албан тушаалтай холбоотой 1 багшийн хүсэлт, 2 багшийн саналыг Захирлын зөвлөлд уламжилж (2019), мөн ШУТИС-ийн ҮЭНХ, хөдөлмөрийн маргаан таслах комиссоор 2 багшийн асуудлыг тус тус шийдвэрлүүлсэн байна.

Гишүүдийн татварыг зөв зохицуулах зарцуулахад ихэд анхааран ажилладаг ба тус хорооны дотоод журмын дагуу тодорхой зүйлд зарцуулдаг. Үүнд:

✓ Багш, ажилтны шинэ жилийн болон багш нарын баярын үйл ажиллагаанд 7,4 сая₮ (Кемпински, Рамада, Чингис ресторан, Ойн жим), хамт олны аялалд тухайлбал 2017 онд Манжуур луу 14 багш, ажилтан, 2018 онд Улаан-Үүд рүү 40 багш, ажилтан, 2019 онд Улаан-Үүдэд 1 багш, 2022 онд Хамрын хийд рүү 22 багшийн аялсан аялалд нийтдээ 5151300₮, багш, ажилтны хүүхдийн бэлгэнд 996200₮ (2019 он), эв санааны нэгдлийн цуглаанд 50000₮ тус тус зарцуулсан.

✓ Гишүүдийнхээ мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд зориулж, 2018 онд БНСУ-д англи хэлний 15 багш, 2019 онд БНСУ-д монгол хэлний 4 багш, ХБНГУ-д 1 багш, Япон улсад ЭШХ-д оролцсон 1 багшид болон хоолны сургалтад хамрагдсан 5 багш, SPSS сургалтын 7 багш, TESOL эрхийн сургалтад 3 багш, нийт 36 багшид 3890000₮-ний дэмжлэг үзүүлсэн.

Хамтын гэрээний дагуу багш, ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2 удаа зохион байгуулж (2018, 2021 он), багш, ажилтнаа хамруулан, 2920000₮ зарцуулсны дээр ковидын үед “Цар тахлыг хамтдаа даван туулья” тусламжийн аяны хүрээнд урьдчилан сэргийлэх, дархлаажуулах ажлыг 2021 онд 2 удаа зохион байгуулж,

хамгаалах хэрэгсэл болох амны хаалт, Монос-Хүнс үйлдвэрийн дархлааг дэмжих Эрүүл мэндийн багцыг гишүүн бүрд хүртээхэд 1038917₮ зарцуулсан байна.

✓ ҮЭ-ийн нэрэмжит багш, ажилтны тэмцээнийг жил бүр уламжлал болгон явуулж ирснийг 2020 оноос багш, ажилтан, төгсөгчдийн 1 төрөлт- волейболын тэмцээн болгон өргөжүүлсэн ба 2017-2020 онд зохиогдсон уг тэмцээнд 2319500₮ зарцуулсан.

✓ Үүнээс гадна гишүүдийн ар гэрт тохиолдсон гачигдал, эмчилгээ, хагалгаа, шагнал урамшуулал, докторын болон профессорын зэрэг хамгаалах, шинэ байранд орох, тэтгэвэрт гарах зэрэгт (2017-2022.09 сар хүртэлх) тусламж, тэтгэмж олгодог журамтай.

✓ ШУТИС-ийн захиргаа, ШУТИС-ийн ҮЭНХ хамтран жил бүр Хамтын гэрээгээ хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр батлуулдаг ба уг гэрээгээр багш, ажилтнаа цалин хөлс, нэмэгдэл урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх харилцааг зохицуулахад ихэд анхаарч, улам боловсронгуй болгохын тулд хамтарч ажилладаг.

ГХС-ийн ҮЭХ нь Хамтын гэрээний биелэлт, хэрэгжилтийн судалгааг жил бүр гаргаж дүгнэх, хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр гаргаж, тайлангийн хурал хийх, сургуулийн ҮЭХ-ны дотоод журмаа шинэчлэн батлах (2017, 2019), хүсэлт гаргасан ажилтныг гишүүнээр бүртгэх, батлах олгох, гишүүдийн судалгааг шинэчлэн гаргах, татварын дүнг жилээр нэгтгэх, татвар ашиглалтыг гишүүн бүрээр гаргаж танилцуулах, гишүүний дэвтэр бөглөх, баримтаа үдэж цэгцлэх, гишүүний гомдол, хүсэлтийг хүлээж авч шийдвэрлэх, тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр гаргах, хурлын протокол хөтлөх, дотоод аудит шалгалтын дүн болон бусад асуудлаар хандсан багш, ажилтанд тухай бүр зөвлөгөө өгөх, удирдах байгууллагыг сонгох, сонгогдох хурал, сургалт, семинарт оролцох, санал өгөх, хууль, дүрэмд зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулах, гишүүддээ дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг багаараа тогтмол гүйцэтгэж ирсэн ба цаашид хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах, бэхжүүлэхийн төлөө идэвхтэй ажиллахаар зорьж байна.

ҮЭХ-ны ажилтан, сонгуультнууд



Дарга Б.Сонинцэцэг
Холбоо барих утас: 11 -324590-2115
soniobyamka@gmail.com



Тэргүүлэгч Т.Цэнд- Аюуш
Холбоо барих утас: 11 -324590-2101
tsendayusht@must.edu.mn



Тэргүүлэгч Б.Мөнхцэцэг
Холбоо барих утас: 11 -324590-2313
muugji_badarch@yahoo.de



Тэргүүлэгч Н.Оюунцэцэг
Холбоо барих утас: 11 -324590-2101
n_ojgoo@must.edu.mn